# ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |
| ЭМДҮЗ | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл |
| ЭМБ | Эрүүл мэндийн байгууллага |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ ..... 3
2.Аудитын тайлан ..... 5
2.1. Оршил ..... 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 10
2.12. Шилэн дансны мэдээлэл ..... 10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ..... 11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 11
3.Менежментийн захидал ..... 12
4.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 15
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 15
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 18
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 24

## 1.Аудитын гэрчилгээ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.02.21 № 06/575

танай ______-ны № ______-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.БАЯСГАЛАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0221SAG20.Docx

001590604

**Аудитын гол асуудал**

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 329,000.0 мянган төгрөгийн программ хөгжүүлэх ажлыг хувь хүнтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн;
- Бараа материалын 62,787.6 мянган төгрөгийн үлдэгдлийг жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй;
- Төсвийн зохицуулалтын зөвшөөрөлгүй 11,512.0 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 15,489.5 мянган төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч зардалд бүртгэсэн

зэрэг нь үнэн зөв, иж бүрэн, оршин байх, тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0221SAG20.Docx

## 2.Аудитын тайлан

### 2.1. Оршил

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Г.Баясгалан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад анхаарах, биет бус хөрөнгийг зөв бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 20–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Л.Мөнхцацрал хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А-1/96 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол хүн бүрийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, даатгалын тогтвортой санг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авдаг үйлчлүүлэгч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэхэд оршино.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Эрүүл мэндийн даатгалын сан бүрдүүлэх, орлого, зарлагын тэнцвэрийг ханган ажиллах, үйл ажиллагаагаа тайлагнах;
- Даатгуулагчийг төлөөлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай тусламж, үйлчилгээний зардлын төлбөр тооцоо хийх гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулах үйл ажиллагааг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.11-д заасан журмын дагуу зохион байгуулах;
- Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт хяналт тавих, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх талаар зөвлөмж, заавар өгөх болон хууль заасан бусад чиг үүрэг

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЭМДҮЗ-ийн 2019 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн салбарт мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны гуравдугаар улирлын мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгөн орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 10,249,620.0 мянган төгрөгөөс тооцон 102,496.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 150,430.4 мянган төгрөгөөр тогтоосон нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 268,053.0 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт орсон мөнгөн хөрөнгийн данс, үндсэн хөрөнгийн данс, урьдчилж гарсан зардал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 637,460.8 | 0 | (637,460.8) |
| Авлага | 125,792.5 | 34,479.0 | (91,199.0) |
| Урьдчилгаа | 0 | 207,512.4 | 207,512.4 |
| Бараа материал | 45,399.4 | 56,787.6 | 11,388.3 |
| Үндсэн хөрөнгө | 2,885,957.1 | 3,663,883.8 | 772,926.7 |
| **Нийт хөрөнгө** | 3,694,609.8 | 3,962,662.8 | 268,053.0 |
| Өр төлбөр | 14,104.0 | 14,644.0 | 540.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,680,505.8 | 3,948,018.8 | 267,513.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 3,694,609.8 | 3,962,662.8 | 268,053.0 |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь оны эхний урсгал зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн ерөнхий татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 125,792.5 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан, тайлант онд Эрүүл хүүхэд, эрүүл шүд аяны зардлын гүйцэтгэлтэй холбоотой 34,479.0 мянган төгрөгийн авлагыг бүртгэсэн байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 207,512.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгуулагчдад зориулж ухаалаг гар утасны апликейшн хөгжүүлэх ажлын урьдчилгаа төлбөрт 46,500.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын цахим системийн өргөжүүлтэд шаардлагатай сервер, серверийн хадгалах төхөөрөмжийн урьдчилгаанд 161,012.4 мянган төгрөгийг оны эцэст шилжүүлж, уг дансанд бүртгэжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 772,926.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь худалдаж авсан үндсэн хөрөнгө болон Эрүүл мэндийн яамнаас 125,079.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь хангамжийн материалын үлдэгдэл 10,824,7 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй болсон 2,300.0 мянган төгрөгийн бараа материал байна.

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ, төлбөр тооцоог хянах 5 программыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, ашиглалтад оруулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 540.0 мянгаар өссөн бөгөөд НДС-гаас балансаас балансад шилжиж ирсэн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,948,018.8 мянган төгрөг болж тайлант үеийн үр дүн 267,513.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны 1,463.5 мянган төгрөгийн залруулга нэмэлт санхүүжилтийн дансаар орсон туслах үйл ажиллагааны орлогыг авлагаар бүртгэснийг залруулсантай холбоотой байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан Эрүүл мэндийн даатгалын сангаас урсгал зардалд 5,109,125.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэл 4,336,758.3 мянган төгрөг буюу 84.9 хувьтай байгаа ба зарцуулагдаагүй үлдэгдэл 772,366.8 мянган төгрөгийг оны эцэст Эрүүл мэндийн даатгалын сангийн ерөнхий дансанд татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардал 772,366.8 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын тасгуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг төсөвлөсөн ч зарцуулаагүйн улмаас 75,371.3 мянган төгрөг, мөн төсвийн төлөвлөлтийг буруу төлөвлөснөөс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 387,815.1 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн зардал 284,138.6 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардал 181,455.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт батлагдаагүй ч Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалд “2106 Эд хогшил, урсгал засварын зардалд байгууллага эд хогшил худалдан авах болон үндсэн хөрөнгөд урсгал засвар, үйлчилгээ хийлгэхтэй холбоотой зардлуудыг тус бүлэгт бүртгэнэ”, “2108 Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардалд байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажиллагсдын ашиглах хэрэглээний программууд, лицензийн төлбөр, тэдгээрийн засвар үйлчилгээг гуравдагч этгээдээс худалдан авахтай холбоотойгоор гарах зардлыг бүртгэнэ” гэж заасныг үндэслэж 882,632.8 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бэлтгэсэн байна.

**Нэмэлт төсөв:** Тайлант онд Эрүүл мэндийн яамны төсөвт төлөвлөгдсөн Эрүүл хүүхэд, эрүүл шүд аян, Гемодиализын үйлчилгээний зардлын санхүүжилтийн 9,640,713.6 мянган төгрөг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 90,965.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,207.0 мянган төгрөг, урд оны гемодиализын санхүүжилтийн авлага 124,205.2 мянган төгрөг нийт 9,858,091.7 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд бүртгэсэн байна.
Үүнээс Эрүүл хүүхэд, эрүүл шүд аяны зардалд 9,496,803.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 173,650.0 мянган төгрөг зарцуулж, 180,558.7 мянган төгрөгийн үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,922,836.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,458,575.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,928.5 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 345,654.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 113,678.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний тайланд 686,209.5 мянган төгрөгийн хөрөнгийн биет ба биет бус хөрөнгө худалдаж авсан зардлыг үйл ажиллагааны мөнгөн зарлагад тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэхдээ 772,366.0 мянган төгрөгийн тохируулгыг дутуу хийсэн нийт 1,458,575.5 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав.

2. Нийгмийн даатгалын сангаас 2018 онд балансаас балансад шилжиж ирсэн 14,104.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй, нийт 14,644.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлагын дүн тооцоо нийлсэн актын дүнгээс 449.0 мянгаар илүү байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 329,000.0 мянган төгрөгийн программ хөгжүүлэх ажлыг хувь хүнтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Мөн ЭМДС-гийн цахим систем программ хангамжийг нэмж хөгжүүлэх хэсэгчилсэн ажлуудыг төсөвт өртгөөс үл хамааруулж, өөр өөр аргачлалаар зохион байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4-т “эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх”; 6 дугаар зүйлийн 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

4. Хувь хүнээр гүйцэтгүүлсэн ажлын үйлчилгээний хөлснөөс 594.5 мянган төгрөгийн татвар суутгаагүй, томилолтын зардлыг 1,640.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т “Нийгмийн даатгалд дор дурдсан ажилтан албан журмаар даатгуулна: 1/өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн”, Татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Албан татвар төлөгчийн татварын жилд олсон дараах орлогод албан татвар

ногдуулна: 8.1.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого" гэсэн заалт болон Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр "Зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаалын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4. Балансад бүртгэлгүй автомашинд болон албан тушаалын болон албан ажлын автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтанд 1,561.0 мянган төгрөгийн шатахууны талон олгож зарцуулсан нь Засгийн газрын 2015 оны "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 184 дүгээр тогтоолын 8-д "...бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай", 2019 оны "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" 6 дугаар тогтоолын 3.1-д "албан тушаалын болон албан ажлын хэрэгцээнд автомашин хэрэглэдэг төрийн албан хаагч өөрөө хүсвэл албан ажлын хэрэгцээнд хувийн автомашин хэрэглэж болно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

5. Үр дүнгийн гэрээ болон ажлын үр дүнд хамааралгүй шалгуураар 900.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн "6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1-т "Онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

6. Анхан шатны баримтгүй 1,794.0 мянган төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч зардалд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 113,678.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Мэдээлэл технологийн хэлтэс нь Эрүүл хүүхэд, эрүүл шүд аян, Гемодиализын үйлчилгээг үзүүлж буй Эрүүл мэндийн байгууллагуудад хуруу уншигч төхөөрөмж суурилуулж даатгуулагчийн авч буй үйлчилгээний тоо, төлбөрийн хэмжээг хянах боломжийг бүрдүүлсэн байна. Эрүүл мэндийн яамнаас санхүүжигдэж буй дээрх төрлийн үйлчилгээний санхүүжилт мэдээлэл технологийн төвийн мэдээллийн сан дахь бүртгэлийн мэдээллийн дагуу байгаа эсэх нь анхаарал татахуйц байна.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 12 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 4 мэдээллийг байршуулаагүй байна.

## 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 637,460,8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 345,727.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг тус тус бүрэн хэрэгжүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 75 хувьтай байна.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Залруулагдаагүй 464,261.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 150,430.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлт өгч байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## 3.Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд орших буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

*3.1.1 Илрүүлэлт:*
ЭМДЕГ нь харилцагч ЭМБ-тай жилийн эцэст тооцоо бодож, үлдэгдлийг баталгаажуулахдаа хүчин төгөлдөр бус маягт /2002 оны 171/111 тоот тушаалын хавсралт/-аар баталгаажуулснаас гадна, 16,696.2 мянган төгрөгийн авлагыг, өглөгтэй гэж буруу тооцоо нийлсэн нь Сангийн сайдын 2017 оны “Маягт батлах тухай” 347 дугээр тогтоолын 4-т “Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан 2002 оны 171/111, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан 2004 оны 213/157 тоот тушаал, Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/22 тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай” гэж заасантай нийцэхгүй байна.

*3.1.2 Эрсдэл:*
Төлбөр тооцоотой холбоотой маргаан үүсэх, зардал буруу илэрхийлэгдэх

3*.1.3 Өгсөн зөвлөмж:*
Тооцооны үлдэгдлийн баталгааг батлагдсан маягтаар, зөв баталгаажуулах

*3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*
Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

### 3.2 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

*3.2.1 Илрүүлэлт:*
Орлого бууруулах бичилтийг буруу хийж мөнгөн гүйлгээний тайланд орлогыг 7,080.0 мянган төгрөгөөр сөрөг дүнгээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Аж, ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ давхар бичилтийн аргаар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

*3.2.2. Эрсдэл:*
Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

*3.2.3. Өгсөн зөвлөмж:*
Төрийн сангийн төлбөр тооцооны системээс үүдсэн алдааг тухай бүр залруулж, орлогын бүртгэлийг стандартад нийцүүлэх

*3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*
Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

**3.3 Бараа материалын данстай холбоотой асуудал**

*3.3.1. Илрүүлэлт:*
Бараа материалын үлдэгдлээс түүвэрлэн тоолоход дансны үлдэгдлээс 223.0 мянган төгрөгөөр илүү, 2,300.0 мянган төгрөгийн ашиглах боломжгүй бараа материалыг өмч хамгаалах комисс албажуулж, данс бүртгэлээс хасаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл: “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа”-ны 2-т “бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*3.3.2. Эрсдэл:*
Хөрөнгө дутагдах, буруу илэрхийлэгдэх

*3.3.3. Өгсөн зөвлөмж:*
Бараа материалын тайланг бодит үлдэгдэлд үндэслэн тайлагнах

*3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар*:
Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

**3.4 Бараа материалын данстай холбоотой асуудал**

*3.4.1. Илрүүлэлт:*
Бараа материалын 62,787.6 мянган төгрөгийн үлдэгдлийг жилийн эцэст тоолж баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/”, 73 дугаар зүйлийн 2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*3.4.2. Эрсдэл:*
Бараа материалын дансны үлдэгдэл, бодит үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлэгдэх

*3.4.3. Өгсөн зөвлөмж*:
Жилийн эцсийн бараа материалын тооллогыг хуульд заасан хугацаанд гүйцэтгэж, тайлагнах.

*3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*
Асуудлын бүртгэлд иргүүлсэн тайлбарын үндэслэлийг хянаж, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

**3.5 Зардлын данстай холбоотой асуудал**

*3.5.1.Илрүүлэлт:*
Төсвийн зохицуулалтын зөвшөөрөлгүй 11,512.0 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн ангиллын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу 15,489.5 мянган төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч зардалд тусгасан, ЭМДҮЗ-ийн хурлын зардалд 492.7 мянган төгрөгийг төсвийн зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5

дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6 дахь “.... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*3.5.2. Эрсдэл:*
Төсвийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулах

*3.5.3. Өгсөн зөвлөмж:*
Батлагдсан төсвийг эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулах

*3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*
Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

**3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний данстай холбоотой асуудал**

*3.6.1.Илрүүлэлт:*
Өмнөх онд үнэлгээ хийж 13,793.9 мянган төгрөгийн газрыг бүртгэсэн маргаантай байгаа газар эзэмших гэрчилгээний асуудлыг шийдээгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 207 тушаалаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийх аргачлал”-д нийцэхгүй байна.

*3.6.2. Эрсдэл:*
Дахин үнэлгээ хийх нөхцөл хангагдахгүй байх, журам зөрчигдөх

3.6.3. Өгсөн зөвлөмж:
Газрыг гэрчилгээжүүлж, холбогдох журмын дагуу үнэлгээг баталгаажуулах

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:
Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

**3.7 Автомашинтай холбоотой асуудал**

*3.7.1. Илрүүлэлт*
ЭМДЕГ-ын балансад бүртгэлтэй 4 автомашиныг суудлын автомашин хэрэглэх эрхгүй албан тушаалтнууд дуудлагаар ашиглаж байгаа нь Засгийн газрын 2015 оны "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 184 дүгээр тогтоол-ын 8-д “...бүх шатны байгууллага, албан тушаалтан эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагаас автомашин гаргуулан хэрэглэх, шатахууны зардлыг төлүүлэхийг тус тус хориглосугай” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*3.7.2. Эрсдэл:*
Үргүй зардал гарах

*3.7.3. Өгсөн зөвлөмж:*
Хот доторх дуудлагын автомашины хэрэглээнд хяналт тавьж, хязгаарлалт хийх

*3.7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*
Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 808,652,625.60 | 298,778,975.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 637,460,773.60 | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 637,460,773.60 | - |
| 3121 | Төгрөг | 637,460,773.60 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 637,460,773.60 | - |
| 33 | АВЛАГА | 125,792,496.00 | 34,479,000.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 124,500.00 | - |
| 335 | Бусад авлага | 125,667,996.00 | 34,479,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 125,667,996.00 | 34,479,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 207,512,356.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 45,399,356.00 | 56,787,619.00 |
| 354 | Хангамжийн материал | 45,399,356.00 | 56,787,619.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,604,820.00 | 6,643,450.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,292,148.00 | 7,292,148.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,621,730.00 | 9,456,694.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,950,000.00 | 3,640,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,930,658.00 | 29,755,327.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,885,957,127.44 | 3,663,883,826.87 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,885,957,127.44 | 3,663,883,826.87 |
| 391 | Газар | 13,793,880.00 | 13,793,880.00 |
| 392 | Биет хөрөнгө | 2,443,979,747.11 | 2,708,083,071.29 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,998,238,855.00 | 1,998,238,855.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (99,959,640.38) | (149,915,611.70) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 196,180,000.00 | 264,780,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (86,802,888.85) | (108,975,888.82) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 385,355,105.00 | 711,373,537.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (160,035,850.91) | (253,215,042.41) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 297,320,257.40 | 342,552,237.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (86,316,090.15) | (116,055,015.18) |
| 393 | Биет бус хөрөнгө | 428,183,500.33 | 942,006,875.58 |
| 39301 | Програм хангамж | 449,555,668.00 | 1,072,718,065.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (21,372,167.67) | (130,711,189.42) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,694,609,753.04 | 3,962,662,801.87 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 14,104,000.00 | 14,644,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 14,104,000.00 | 14,644,000.00 |
| 413 | Өглөг | 14,104,000.00 | 14,644,000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | |
| 4136 | Бусад өглөг | 14,104,000.00 | 14,644,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 14,104,000.00 | 14,644,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,680,505,753.04 | 3,948,018,801.87 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,680,505,753.04 | 3,948,018,801.87 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 13,793,880.00 | 13,793,880.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 13,793,880.00 | 13,793,880.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,666,711,873.04 | 3,934,224,921.87 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 3,665,248,373.04 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 3,666,711,873.04 | 268,976,548.83 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,694,609,753.04 | 3,962,662,801.87 |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 9,412,659,318.34 | 15,049,041,876.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,368,850,918.34 | 206,029,622.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,368,850,918.34 | 206,029,622.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,364,733,406.34 | 193,679,984.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,364,733,406.34 | 193,679,984.00 |
| 120009 | Бусад орлого | 4,117,512.00 | 12,349,638.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 7,043,808,400.00 | 14,843,012,254.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,870,457,000.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,870,457,000.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,173,351,400.00 | 9,733,887,154.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 173,351,400.00 | 90,965,904.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000,000,000.00 | 9,640,713,550.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 2,207,700.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | - | 5,109,125,100.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | - | 5,109,125,100.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 5,745,947,445.30 | 14,780,065,327.17 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,745,947,445.30 | 14,780,065,327.17 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,854,330,741.30 | 3,608,093,173.59 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,702,454,925.00 | 2,123,798,044.52 |
| 210101 | Үндсэн цалин | 1,679,607,578.00 | 2,048,251,754.52 |
